



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ**

2021 оны 11 сарын 24 өдөр

Дугаар 108

Мандалговь

**Үндсэн хөрөнгө акталж данснаас хасах,
автомашинд үнэлгээ тогтоож, худалдах
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.2, 6 дугаар зүйлийн 6.2.1, 6.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Хот тохижуулах газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 6,803,323 (зургаан сая найман зуун гурван мянга гурван зуун хорин гурав) төгрөгийн балансын үнэ бүхий нэгдүгээр хавсралтад заасан 2 ширхэг автомашиныг акталж, акталснаас гарсан сэлбэгийг эргэлтийн хөрөнгөд бүртгэх, 4,312,500 /дөрвөн сая гурван зуун арван хоёр мянга таван зуу/ төгрөгийн балансын үнэ бүхий 2 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч худалдах доод үнийг хоёрдугаар хавсралтад заасны дагуу тогтоосугай.

Хоёр: Эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Гантулга)-д үүрэг болгосугай.

Гурав: Хот тохижуулах газрын дарга (Д.Очбадрах)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

3.1 Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийг акталж, акталснаас гарсан сэлбэгийг эргэлтийн хөрөнгөд бүртгэх, хаягдал төмрийг борлуулж, орлогыг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэх;

3.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;


3.3 Акталж, данснаас хассан автомашины улсын дугаарыг улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулах, худалдсан автомашиныг улсын бүртгэлээс шилжүүлэх;

3.4 Энэ тогтоолын биелэлтийг 2021 оны 4 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

Дөрөв: Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны .11 дүгээр сарын
24-өдрийн 128 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт



Хот тохижуулах газрын актлах тээврийн хэрэгслийн жагсаалт

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Үйлдвэрлэсэн он	Ашиглалтад орсон огноо	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
			Сери	Дугаар					
1	Өөрөө буулгагч	Зил MMZ4505	ДУА	33-79	1992	1992	2,803,323	1,888,349.44	914,973.56
2	Тусгай зориулалтын	DONGFEN G	ДУА	39-08	2007	2007	4,000,000	2,777,777.75	1,222,222.25
Нийт хөрөнгийн дүн							6,803,323 /зургаан сая найман зуун гурван мянга гурван зуун хорин гурван төгрөг/		

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2021 оны 11 дүгээр сарын
24-өдрийн 128 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



Хот тохижуулах газрын актлах, дуудлагаар худалдах тээврийн хэрэгслийн жагсаалт

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Үйлдвэрлэсэн он	Ашиглагдсан орсон он	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Худалдах доод үнэ
			Сери	Дугаар						
1	Ачааны	KIA Fronter	ДУА	53-65	2001	2009	312,500	312,500	0	1,000,000
2	Тусгай зориулалтын	DONGFENG	ДУА	76-44	2007	2007	4,000,000	2,777,777.75	1,222,222.25	1,000,000
Нийт хөрөнгийн дүн							4,312,500 /дөрвөн сая гурван зуун арван хоёр мянга таван зуун төгрөг/			